

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

(Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл)

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл/цаашид “хуулийн төсөл” гэх/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг үндэслэн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”/цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Уг аргачлалд заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог бөгөөд хуулийн төслөөр нийтлэг байдлаараа хуулийн этгээд, төрд шинэ чиг үүрэг нэмэх, шинээр үүрэг хүлээлгэх зохицуулалтуудыг тусгасан байна.

Хуулийн төсөл нь төрийн холбогдох байгууллагуудад хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотойгоор тодорхой үүргүүдийг бий болгосон бөгөөд аргачлалд заасны дагуу хуулийн төслийн зохицуулалтаар шинээр орж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцсон болно. Тухайлбал, хуулийн төслөөр Засгийн газар, Хууль зүйн туслалцааны төвийн зэрэгт шинээр нэмэгдэж байгаа үүрэг тус бүрийг тодорхойлж, төрд үүсэх зардлын тооцоог субъект тус бүрээр тооцохыг зориллоо.

Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн хүрээнд нэг төрийн байгууллагаас нөгөөд шилжиж байгаа чиг үүргийг тооцох шаардлагагүй тул тооцоогүй болно.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- хуулийн этгээд, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Нэг.Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал

Хуулийн төсөлд төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараахь үе шаттайгаар гаргалаа:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;

2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийг хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягтлах.

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон. Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах нь зүйтэй.

Үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт ажлын байрны зураг авалтын үр дүнд гаргасан хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200¹ өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /хөдөлмөрийн хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ 96000 минут ажиллана гэсэн үг.

Монгол Улсын Засгийн газар

15 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

15.1.Засгийн газар хууль зүйн туслалцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.хууль зүйн туслалцааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

15.1.2.Төвийн удирдах болон гүйцэтгэх албан тушаал, улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн туслахын албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох.

Монгол Улсын Засгийн газар нь дээрх зүйлд тусгагдсан үйл ажиллагааг зохион байгуулах давтамж тогтмол биш эсхүл жилдээ 1 гүйцэтгэх тул аргачлалын дагуу давтамжийг 1, тохиолдлын тоог мөн 1 гэж тооцлоо.

¹Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Тоон үзүүлэлт /мин
Хууль зүйн туслалцааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих	1 агуулгатай	мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		танилцах, мэдээллээ үнэлэх	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		боловсруулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		нэгтгэн дүгнэх	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		шийдвэрлэх, албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
		Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
Төвийн удирдах болон гүйцэтгэх албан тушаал, улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн туслахын албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох	1 агуулгатай	мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		танилцах, мэдээллээ үнэлэх	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		боловсруулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		нэгтгэн дүгнэх	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		шийдвэрлэх, албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
		Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
					19620

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Засгийн газар	32640 мин	96000	0,2

Монгол Улсын Засгийн газар нь хууль зүйн туслалцааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, Төвийн удирдах болон гүйцэтгэх албан тушаал, улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн туслахын албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэхэд 48000 цагийн ачаалал үүсч байгаа бөгөөд энэ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 0,2 хүн шаардлагатай гэсэн тооцоолол гаргалаа. Өөрөөр хэлбэл, уг ажлыг хариуцсан орон тоо гаргах шаардлагагүй бөгөөд одоо ажиллаж байгаа албан хаагчаар хариуцан гүйцэтгүүлэх боломжтой юм.

Иймээс дээрх ажлыг гүйцэтгэхэд хүний нөөцийн хэрэгцээ шаардлага Засгийн газарт шинээр болохгүй гэдэг нь тодорхой харагдаж байна.

Хууль зүйн туслалцааны төв

12 дугаар зүйл.Төвийн чиг үүрэг

11.1.Төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.12.эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулах, бусад байгууллагатай хамтран ажиллах;

11.1.11.хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар төрийн байгууллага, хуулийн этгээдтэй хамтран ажиллах;

Хуулийн төсөлд шинээр тусгагдсан Хууль зүйн туслалцааны төвийн чиг үүргийг үйл ажиллагааны онцлогоос хамаарч давтамжийг өөр өөрөөр тогтоолоо.

Ингэхдээ шинээр үүссэн үүрэг тул энэ талаар тогтсон практик байхгүй байгаа тул ижил төрлийн чиг үүрэг хэрэгжүүлдэг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2017 оны тайлан мэдээнээс үзэхэд сургалт нийт 13 удаа, сурталчилгаа нийт 60 удаа хийсэн дүн мэдээнд үндэслэн дунджаар тооцлоо.

Харин хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар төрийн байгууллага, хуулийн этгээдтэй хамтран ажиллах чиг үүргийг бүрэн тодорхойлох боломжгүй тул тооцоогүй болно.

Мэдээлэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин
Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулах, бусад байгууллагатай хамтран ажиллах;	мэдээлэл цуглуулах	2 өдөр /16цаг/ 960 мин	50	48000
	танилцах, мэдээллээ үнэлэх	1 өдөр /8 цаг/ 480 мин	50	24000
	нягтлах	1 өдөр /8цаг/ 480 мин	50	24000
	Боловсруулах	2 өдөр /40цаг/ 960 мин	50	48000
	Нягталж, албажуулах	1 өдөр /8цаг/ 480 мин	50	24000
	Мэдээллээ түгээх	1 өдөр /8цаг/	50	24000

		480 мин		
				209760

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Хууль зүйн туслалцааны төв	192000 мин	96000	2

Хууль зүйн туслалцааны төв нь эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулах, бусад байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэхэд 192000 цагийн ачаалал үүсч байгаа бөгөөд энэ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 2 хүн шаардлагатай гэсэн тооцоолол гаргалаа.

Иймээс дээрх ажлыг гүйцэтгэхэд хүний нөөцийн хэрэгцээ шаардлага 2 хүнээр нэмэгдэж байгаа нь харагдаж байна.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Хууль зүйн туслалцааны төвөөс бүтэц орон тоо, үйл ажиллагаанд хамаарах төсөв, санхүүгийн тооцооллыг дараах байдлаар урьдчилан тооцов.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл /5.1.1.хууль зүйн зөвлөгөө өгөх, 5.1.2.өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, 5.1.3.эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх/-ийн дагуу төвийн бүтцэд төвийн ажлын алба, нэгжид ажиллах удирдах, гүйцэтгэх, туслах чиг үүргийн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч 27, салбарын дарга буюу улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, өмгөөлөгчийн туслах 174 нийт 201 албан хаагч байхаар тооцов.

Цалингийн зардал:

Хууль зүйн туслалцааны төвийн ажлын алба 2018 онд 13 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байсан бол хуулийн төсөлтэй холбогдуулан орон тоог 27 байхаар тооцож, шинээр нэмэгдсэн 14 албан хаагчийн цалин нэмэгдэл нийт зөрүү **166.571.052** төгрөг байна. /Хүснэгт-1/

**ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДАГУУ
ХЗТТ-ИЙН АЖЛЫН АЛБАНД ШИНЭЭР ХИЙГДЭЖ БУЙ БҮТЭЦ ОРОН ТОО, ЦАЛИНГИЙН ТООЦОО**

/хүснэгт-1/

д/д	Албан тушаал	Ангилал	Орон тоо			Ангилал зэрэглэл	Үндсэн цалин	нэмэгдэл			Сарын цалин	Жилийн цалин
			Одоо байгаа	Хуулийн төсөлөөр нэмэгдэх	Нийт			Зэрэг дэв	Ур чадвар	Унаа хоол		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Төвийн захирал	Эрхэлсэн тушмал	1	-	1	T3-12-5	921067	-	-	-	-	-
2	Ажлын албаны дарга	Ахлах тушмал	-	1	1	T3-9-5	864211	216052	-	121000	1.201.263	14.415.156
3	Хэлтсийн дарга	Ахлах тушмал	1	1	2	T3-8-5	859609	214902	-	121000	1.195.511	14.346.132
4	Ахлах мэргэжилтэн	Дэс тушмал	3	3	6	T3-6-5	731631	182907	-	121000	3.106.614	37.279.368
5	Мэргэжилтэн	Дэс тушмал	6	4	10	T3-5-5	678611	169652	-	121000	3.877.052	46.524.624
6	Нягтлан бодогч	Мэргэжлийн албан хаагч	1	-	1	TУ-7-5	657134	-	164283	121000	942.417	11.309.004
7	Нярав	Техникийн гүйцэтгэх албан хаагч	1	-	1	TУ-4-5	506633	-	126658	121000	-	-
8	Жолооч	Техникийн гүйцэтгэх албан хаагч	-	3	3	TУ-3-5	488327	-	122081	121000	2.194.224	26.330.688
9	Үйлчлэгч	Үйлчилгээний албан хаагч	-	2	2	TУ-1-5	448736	-	112184	121000	1.363.840	16.366.080
Нийт:			13	14	27		6.155.959	1.013.779	525.206	1.089.000	13.880.921	166.571.052

Тайлбар: Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан төвийн ажлын алба, салбарын албан хаагчдын шинээр нэмэгдсэн орон тоогоор цалинг тооцов. УИХ-ын 1995 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" 73 дугаар тогтоол, Засгийн газрын 1995 оны "Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай" 96 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны "Төрийн зарим албан тушвааны цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 264 дүгээр тогтоолын 7, 9 дүгээр хавсралтын дагуу цалин нэмэгдлийн хэмжээг тооцов.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн 10 дугаар зүйл /10.7.Салбарт улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, өмгөөлөгчийн туслах ажиллана./-ийн дагуу Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн харьяаллын дагуу салбарын тоог 38 болгож 7 салбарыг шинээр байгуулахаар төлөвлөсөн.

Салбарын захиргааны үйл ажиллагааг улсын ахлах өмгөөлөгч хариуцан гүйцэтгэж байсан бол хуулийн төслөөр улсын ахлах өмгөөлөгчийг улсын өмгөөлөгч болгож салбарын захиргааны чиг үүргийг гүйцэтгэх салбарын даргаар 30 албан хаагчийг шинээр нэмэгдүүлсэн. Орон нутгийн 38 салбараас 8 /зарим сумдын/ салбарыг тухайн аймаг, нийслэлийн төвийн салбарт захиргааны чиг үүргийг нэгтгэж, 30 байхаар тооцож цалин нэмэгдлийн хэмжээг гаргавал **382.789.488** төгрөг байна. /Хүснэгт-2/

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлд Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах хүний хамрах хүрээг нэмэгдүүлж өөрөөр хэлбэл зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагч тал бус гэмт хэргийн хохирогч, зарим иргэний хэргийн зохигч болон захиргааны хэргийн оролцогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа

үзүүлэхтэй холбогдуулан 52 улсын өмгөөлөгчийг 104, өмгөөлөгчийн туслах 7 байсныг 31 байхаар тооцоход **815.251.776** төгрөг байна.

/Хүснэгт-2/

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДАГУУ
ХЗТТ-ИЙН САЛБАРУУДАД ШИНЭЭР ХИЙГДЭЖ БУЙ БҮТЭЦ ОРОН ТОО, ЦАЛИНГИЙН ТООЦОО

д/д	Албан тушаал	Ангилал	Орон тоо			Ангилал, зэрэглэл	Үндсэн цалин	Зэрэг дэв	Ур чадвар	Унаа хоол	Сарын цалин	Жилийн цалин
			Одоо байгаа	Хуулийн төслөөр нэмэгдэх	нийт							
1	Салбарын дарга /дүүрэг/	Ахлах түшмэл	-	7	7	ТЗ-7-5	792572	183465	-	121000	7672273	92151276
	Салбарын дарга /орон нутаг/	Ахлах түшмэл	-	23	23	ТЗ-7-5	792572	183465	-	77000	24219851	290638212
2	Улсын өмгөөлөгч /дүүрэг/	Төрийн үйлчилгээ	21	17	38	ТҮ-10-5	734053	-	183513	121000	17655622	211867464
	Улсын өмгөөлөгч /орон нутаг/	Төрийн үйлчилгээ	31	35	66	ТҮ-10-5	734053	-	183513	77000	32359810	388317720
3	Өмгөөлөгчийн туслах /дүүрэг/	Төрийн үйлчилгээ	3	6	9	ТҮ-4-5	506633	-	152126	121000	4678554	56142648
	Өмгөөлөгчийн туслах /орон нутаг/	Төрийн үйлчилгээ	4	18	22	ТҮ-4-5	506633	-	152126	77000	13243662	158923944
4	Оператор /хуульч, өмгөөлөгч/	Төрийн үйлчилгээ	-	9	9	ТҮ-10-5	734053	-	183513	121000	9.347.094	112.165.128
Нийт:			59	115	174		4066516	366930	671278	594000	221341994	1310206392

Тайлбар: Хууль зүйн туслалцааны төвийн нийслэл болон орон нутагт ажиллах албан хаагчдын цалингийн тооцоог хүснэгтийн багана 2 дугаарт хамаарах зөөхөн шинээр бий болж буй ажлын байр, орон тоогоор тооцов.

Хуулийн төсөлтэй холбогдуулан хийгдсэн бүтэц орон тоогоор нийт цалин **1.476.777.444** төгрөгөөр нэмэгдсэн.

Цалингаас бусад тогтмол шинжтэй урсгал зардал:

Хууль зүйн туслалцааны төвийн цалингаас бусад тогтмол шинжтэй урсгал зардлыг Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргавал:
/хүснэгт-3/

ЦАЛИНГААС БУСАД ТОГТМОЛ ШИНЖТЭЙ УРСГАЛ ЗАРДЛЫН ТООЦОО

/хүснэгт-3/

№	Зардлын төрөл /эдийн засгийн ангилал/	Зардлын хэмжээ
1	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	209.474.900
2	Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	11.233.800
2.1	Байрны түрээс	11.233.800
3	Хангамж бараа материалын зардал	53.473.500
3.1	Бичиг хэрэг	21.583.200
3.2	Тээвэр /шатахуун/	15.669.200
3.3	Шуудан холбоо	7.007.000
3.4	Ном хэвлэл	3.720.000

3.5	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5.494.400
4	Эд хогшил, урсгал засварын зардал	20.196.500
4.1	Багаж, техник хэрэгсэл	12.402.600
4.2	Урсгал засварын зардал	7.793.900
5	Томилолт, зочны зардал	48.183.700
5.1	Гадаад томилолт	35.000.000
5.2	Дотоод албан томилолт	13.183.700
6	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	30.475.500
6.1	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5.723.000
6.2	Даатгалын үйлчилгээ	503.000
6.3	Тээврийн хэрэгслийн татвар	181.200
6.4	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220.200
6.5	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	252.500
6.6	Мэдээлэл, сурталчилгааны зардал	4.520.000
6.7	Өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс	10.692.000
6.8	Мэдээлэл технологийн үйлчилгээ /мэдээллийн сан/	8.383.600
7	Бараа үйлчилгээний бусад зардал	60.473.000
7.1	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	3.620.000
7.2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56.853.000
8	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшуулал	27.260.800
8.1	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	27.260.800
9	Хөрөнгө оруулалт	1.367.000.000
9.1	Тээврийн хэрэгсэл	585.000.000
9.2	Тавилга, тоног төхөөрөмж	300.000.000
9.3	Машин, тоног төхөөрөмж	432.000.000
9.4	Мэдээллийн сангийн программ	50.000.000
Нийт дүн:		1.782.050.277

Нийт зардал **3.258.827.721** төгрөг байна.

Хоёр.Хуулийн этгээдэд үүсэх зардал

Захиргааны аргаар аж ахуйн нэгжид үүрэг хүлээлгэж байгаа нь хувийн хэвшилд үүсч байгаа зардал юм. Аж ахуйн нэгжээ дэмжих бодлого баримталж байгаа бол захиргааны аргаар үүрэг аль болох бага хүлээлгэх хэрэгтэй байдаг.

Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцохдоо төрд захиргааны зардал тооцдогтой адил тооцно. Энэхүү зохицуулалт нь Монгол Улсад анх удаа, цоо шинээр бий болох үйл ажилллагаа тул бэлэн тоо баримт байхгүй, мөн баримжаалах баримт байхгүй гэдгийг энд дурдах нь зүйтэй.

Нэг мэдээлэх үүрэг нь хэд хэдэн үүрэг агуулж байж болно.

Хуулийн этгээдэд үүсэх зардлыг төрийн байгууллагад мэдээлэх үүрэг буюу Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хууль зүйн туслалцааны мэдээллийн санд хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа байгууллагууд мэдээллээ оруулах үүрэгтэй” гэж мэдээлэх үүргийг заасан байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль болон өмнөх практикт энэ талаар

тодорхой практик байхгүй, төлөвшөөгүй тул зардлыг дараахь байдлаар тоймлон тооцлоо.

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг
Хууль зүйн туслалцааны мэдээллийн санд хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа байгууллагууд мэдээллээ оруулах үүрэгтэй	-Хуульчдийн холбоо -Өмгөөлөгчдийн холбоо -Хууль зүйн клиник төв	Хууль зүйн туслалцааны санд мэдээлэл оруулах

Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд ажлын цагийг долоо хоногийн ажлын цаг нь 40, ердийн ажлын үргэлжлэх хугацаа 8 хүртэл цаг байна.

Тиймээс ажилтан сард ажиллах хугацааг нь 5 хоног буюу 40 цаг /5*8/, 2400/40*60/ мин байна.

Мэдээлэх үүрэг хүлээсэн хуулийн этгээдийн гүйцэтгэх, боловсруулах чиг үүрэг ажилтан буюу мэргэжилтэн нь хуулийн төсөлд заасан материалыг боловсруулж, бүрдүүлэх ажлыг гүйцэтгэнэ гэж үзсэн бөгөөд Үндэсний статистикийн хорооноос зарласан 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар аж ахуйн нэгж байгууллагын мэргэжилтний дундаж цалинг 1025.800 төгрөг байна гэж тооцлоо.

Дээр тооцож гаргасан үндсэн цалин, ажиллах хугацаагаар ажилтны ажлын хөлсийг тооцвол

Үндсэн цалин		Ажиллах хугацаа		Ажлын хөлс
1025800	/	2400	=	427

Хуулийн заалт	Мэдээлэх үүрэг	Мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	хугацаа	Ажлын хөлс /төг/	Зардал /төгрөг
28 дугаар зүйл	Хууль зүйн туслалцааны мэдээллийн санд хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа байгууллагууд мэдээллээ оруулах үүрэгтэй	Хууль зүйн туслалцаа үзүүлсэн талаар тоо, тайлан мэдээ хүргүүлж, санд оруулах	Мэдээлэл цуглуулах	60	427	25620
			Мэдээллүүдийг боловсруулах	120	427	51240
			Мэдээллийг нягтлах	60	427	25620
			Албан бичиг боловсруулах	20	427	8540
			Санд оруулах	30	427	12810
			Холбогдох газар хүргүүлэхээр шууданд хийх	5	427	2135
						125965

Хуулийн төслийн 11.4-т “Шаардлагатай тохиолдолд зохицуулах хороо нэмэлт материалыг хүсэлт гаргагчаас авч болно.” гэж заасан. Ямар нэмэлт материал шаардах нь тодорхойгүй байх тул энэ зохицуулалт дээр зардал тооцоогүй болно.

<u>Заалт</u>	<u>Мэдээлэх үүрэг</u>	<u>Мэдээллийн агуулга</u>	<u>Стандарт үйл ажиллагаа</u>	<u>Тохиодлын тоо</u>	<u>давтамж</u>	<u>Тоон үзүүлэлт</u>
28.3	Хууль зүйн туслалцааны мэдээллийн санд хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа байгууллагууд мэдээллээ оруулах үүрэгтэй	Хууль зүйн туслалцаа үзүүлсэн талаар тоо, тайлан мэдээ хүргүүлж, санд оруулах	Мэдээлэл цуглуулах	12	1	12
			Мэдээллүүдийг боловсруулах	12	1	12
			Мэдээллийг нягтлах	12	1	12
			Албан бичиг боловсруулах	12	1	12
			Санд оруулах	12	1	12
			Холбогдох газар хүргүүлэхээр шууданд хийх	12	1	12
						12

Тоон үзүүлэлт **12** гэж гарлаа. Энэхүү зохицуулалтын хүрээнд мэдээллийг хүргүүлж байх тодорхой хугацаа заагаагүй журмаар зохицуулахаар тусгасан тул мэдээлэх үүргийн хугацаа харьцангуй цөөн байна гэж үзэн тохиолдлын тоог 12 гэж авлаа.

Нийт зардал = зардал* тоон үзүүлэлт

12*125965=1511580 төгрөг

Ингээд мэдээлэх үүрэг хүлээгч хуулийн этгээдээс гарах нийт зардал **1511580** төгрөг гарсан байна.

Дүгнэлт

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн төрийн байгууллага, хуулийн этгээдэд бий болох зардлын тооцлоо. Хуулийн төсөлд Засгийн газраас хууль зүйн туслалцааны талаар төрөөс баримтлах бодлогыг батлах, төвийн удирдах болон гүйцэтгэх, албан тушаалтан, салбарын даргын албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоохоор тусгасан байна. Иймээс Монгол Улсын Засгийн газраас эдгээрийг батлахтай холбоотойгоор хүний нөөцийн зардал гарахааргүй байна.

Хуулийн төслөөр хууль зүйн туслалцаа үзүүлэх хүрээ болон хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүний хамрах хүрээг нэмэгдүүлж зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчаар хязгаарлахгүйгээр гэмт хэргийн сэжигтэн, шүүгдэгч, хохирогч, иргэний хэргийн зохигч болон захиргааны хэргийн нэхэмжлэгчид үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төвийн бүтэц, орон тоо өөрчлөгдөхөөр байна. Өрөөр хэлбэл, энэ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд тодорхой хэмжээний хүний нөөцийн ачаалал үүсэж, түүнтэй холбоотойгоор бусад зардал одоо байгаа хэмжээнээс нэмэгдэхээр буюу нийт зардал **3.258.827.721** төгрөг болохоор урьдчилсан тооцоо гаргасан. Гэхдээ гарч болох зардлыг хуулийн төслийн ач холбогдолтой харьцуулахад төдийлөн их биш гэж үзэж байна.

Мөн хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцоход мэдээлэх үүрэг хүлээсэн хуулийн этгээдэд гарах нийт зардал **1511580** төгрөг гарсан байна. Эдгээр нь мэдээлэл цуглуулах, боловсруулах, илгээх зэрэг хуулиар тогтоосон шаардлагуудыг биелүүлж ажиллахад гарах чиг үүргийн зардал болно.

Хуулийн төсөлд мэдээлэх үүргийн хугацааг тодорхой зохицуулаагүй, журмаар зохицуулахаар тусгасанаас тохиолдлын тоо болон давтамж нь харьцангуй цөөн байгаа нь нийт зардлын эцсийн дүнд ийнхүү нөлөөлсөн гэдгийг энд дурдах нь зүйтэй.

Санал:

- Хуулийн төслөөр Хууль зүйн туслалцааны төвийн салбар нь даргатай байхаар хуульчилжээ. Тодруулбал, энэ албан тушаалтай холбоотойгоор төрл 30 албан хаагчийг шинээр нэмэгдүүлэн, төсөвт **382.789.488** төгрөгийн цалингийн зардал гарахаар байна. Гэтэл салбарын дарга нь ямар чиг үүрэгтэй байх талаар хуулийн төсөлд тодорхой зохицуулалт тусгагдаагүй байгаа нь бусад албан хаагчидтай чиг үүргийн хувьд давхардал үүсгэх, тодорхойгүй байдлыг бий болгохоор байна. Иймд салбарын дарга ямар чиг үүрэгтэй байх талаар хуулийн төсөлд нарийвчлан тусгах, эсхүл салбарын дарга гэсэн албан тушаалыг хасах шаардлагатай бөгөөд чиг үүргийн давхардал бий болгохгүй байхад анхаарах.
- Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.3-т “Хууль зүйн туслалцааны мэдээллийн санд хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа байгууллагууд мэдээллээ оруулах үүрэгтэй” гэж заасан боловч ямар мэдээллийг, ямар хугацаанд, ямар байгууллага оруулах нь тодорхойгүй байна. Иймд мэдээллийг агуулга, төрөл, мэдээлэл оруулах байгууллага зэргийг хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна.